



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/46


Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн "Улсын аварга малчин өрх, Улсын хошой аварга малчин өрх, Улсын аварга саальчин, Улсын аварга фермер, улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланч шалгаруулах тухай" 30 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 61 дүгээр тушаалын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Улсын аварга малчин өрх"-өөр шалгарсан Сүмбэр сумын Малх багийн малчин Жийеэгийн Бат-Очир, Сүмбэр сумын Уулзвар багийн малчин Төмөрчулууны Батжаргал, Баянтал сумын Лүн багийн малчин Гэрэлбадрахын Мөнхбаяр нарт хүндэтгэл үзүүлэхэд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Шагналд зарцуулагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Г.БАТСУУРЬ

4212400126

Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дүгээр сарын 30-ны өдрийн
А/46 дугаар захирамжийн
хавсралт

УЛСЫН АВАРГА МАЛЧИНД ОЛГОХ ШАГНАЛЫН
ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо/хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Календарь	ш	3	4,500	13,500
2	Торго	м	3	50,000	150,000
3	Бэлэгний уут	ш	3	3,500	10,500
4	Чацаргана	кг	3	18,000	54,000
5	Сүү	л	3	6,000	18,000
6	Хадаг	ш	3	8,000	24,000
7	Боржигин морин хуур	ш	3	850,000	2,550,000
8	Өргөмжлөл	ш	3	60,000	180,000
НИЙТ ҮНЭ				1,000,000	3,000,000

